

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Самдандагва	Дугаар	L315
Оршин суугаа аймаг	Өвөрхангай	Оршин суугаа сум	Арвайхээр
Төрсөн газар	Арвайхээр	Төрсөн он	1922
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Арвайн хүрээ	Сүм хийдийн дугаар	ӨХАХ 041
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 9	Ярилцлага авсан хүн	Жужа

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Арвайн хүрээ

Жужа: Хуучин Арвайхээрийн хүрээний талаар хэлж өгнө үү? Хэдэн дугантай, хэдэн ламтай?

Самдандагва: Урд улаан лам дээр байсан юм. Цогчин дуган, чойрын дуган.

Жужа. Та өөрөө аль дуганд хурдаг байсан юм?

Самдандагва: Аль алинд нь хурдаг байсан юм. Лам нь цөөхөн.

Жужа. Яг ямар нэртэй хүрээнд сууж байсан бэ?

Самдандагва: Арвайхээрийн хүрээ.

Жужа: Хэдэн ламтай байсан бэ?

Самдандагва: За нэг 20-иод лам суудаг байсан байх аа.

Жужа: Тэргүүн лам нь хэн байсан бэ?

Самдандагва: Аа мэдэхгүй, мартчихаж.

Жужа: Хэдэн дуган байсан бэ?

Самдандагва: Хоёр дуган байсан юм. Цогчин, чойр.

Жужа: Модон дуган байсан уу?

Самдандагва: Тийм.

Жужа: Хашаан дотор байсан уу?

Самдандагва: Тэгэлгүй яахав.

Жужа. Суварга байсан уу?

Самдандагва: Байсан, 2 суварга байсан.

Жужа: Хаана байсан бэ?

Самдандагва: Хийдийнхээ урд талд.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Гол шүтээн сахиус нь?

Самдандагва: Дамдин чойжоо.

Жужа: Сарын дүйчэн өдрүүдэд ямар ямар хурал хурдаг байсан бэ?

Самдандагва: Сахиусаа уншина. Арван хангалаа уншина.

Жужа: Ганжуур , майдар эргэдэг байсан уу?

Самдандагва: Майдар эргэдэг байсан. Ганжуур эргэдэг байсан.

Жужа: Майдар яг хэзээ эргэдэг байсан, ямар улиралд?

Самдандагва: Мэдэхгүй ээ, зуны адаг сарын шинийн найманд эргэдэг байх аа.

Жужа: Хайлан хурдаг байсан уу?

Самдандагва: Хурдаг байсан.

Жужа: Зоч лүйжин тавьдаг лам нар байсан уу?

Самдандагва: Байх нь байсан. Тэр зоч улсууд чинь тусдаа улсууд байсан.

Жужа: Хэдэн зоч лам нар байсан бэ?

Самдандагва: 20-иод хүн байсан юм байгаа биз.

Жужа. Зоч лам нар модон дуганд байсан уу?

Самдандагва: Тийм.

Жужа: Хийдээсээ аль зүгт байсан юм бэ?

Самдандагва: Урд зүгт.

Жужа: Яагаад тэр хийдийг Улаан ламын хийд гэж нэрлэсэн юм бэ?

Самдандагва: Хуучны нэр нь тийм.

Жужа: Сумын төвөөсөө аль зүгт?

Самдандагва: Баруун урагшаа 45, 46 км-т.Одоо хийд байгаа, шинээр. Лам нар ч байгаа.

Жужа: Хийдийг хэзээ нураасан бэ?

Самдандагва: Үгүй ээ, нураагаагүй юм.

Жужа: Хэдэн нас хүртлээ шавилан сууж байсан бэ?

Самдандагва: Мэдэхгүй, энэ чинь одоо...

Жужа: Хэзээ хар болсон бэ?

Самдандагва. Хар бол болоогүй, ламаараа.